



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 1/129


Улаанбаатар хот

Шагнах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Худалдаа үйлчилгээний салбарыг хөгжүүлэх их үйл хэрэгт үнэтэй хувь нэмрээ оруулан оюун ухаанаа дайчлан ажиллаж байгаа Баянзүрх дүүргийн 21 дүгээр хорооны иргэн Чулуунбатын Хонгорзулыг Хотын Ерөнхий менежерийн шагналын журмын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтын дагуу Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн “Өргөмжлөл”-өөр шагнасугай.

2. “Өргөмжлөл”-ийг дагалдах мөнгөн шагнал болох 50,000 /тавин мянга/ төгрөгийг өөрийн байгууллагын санхүүгээс гарган урамшуулахыг байгууллагын удирдлагад мэдэгдэхийг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Э.Энхцэцэг/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

